

Российская академия наук
Институт восточных рукописей
(Азиатский Музей)



Адрес учредителя: 191181,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Адрес редакции: 191181,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Адрес издателя: 191181,
Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Тел.: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

Регистрационный номер
свидетельства о регистрации
средства массовой информации
ПИ No ФС77-79202
от 22 сентября 2020 г.

ISSN 2311-5939

DOI

MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведных исследований

Том XXIX • 2026 • № 3

Выходит 4 раза в год

Издается с 1986 г.

Учредитель: ФГБУН

Институт восточных рукописей РАН

Редакционная коллегия:

И. В. Кульганек, *главный редактор,*
доктор филологических наук (Россия)

Д. А. Носов, *секретарь редколлегии, кандидат*
филологических наук (Россия)

М. А. Козинцев, *помощник секретаря,*
кандидат исторических наук (Россия)

Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*

А. Бирталан, *доктор наук (Венгрия)*

Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*

Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*

И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор РАН*
(Россия)

Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*

В. Капишовска, *доктор наук (Чехия)*

Э. Мунхцэцэг, *кандидат филологических наук*
(Монголия)

С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*

К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*

М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*

Р. Поп, *доктор наук (Румыния)*

Ц. Саранцацрал, *доктор филологических наук*
(Монголия)

Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, профессор*
(Россия)

С. Чулуун, *академик МАН (Монголия)*

Е. Э. Хабунова, *доктор филологических наук (Россия)*

Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*

Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет – М. В. Алексеева

Литературные редакторы и корректоры – И. В. Кульганек, Д. А. Носов

Технический редактор – М. А. Козинцев

Подписано в печать 15.09.2026

Формат 60×90 1/8. Объем 10 печ. л. Заказ №

Тираж 300 экз.

Отпечатано в типографии ООО «Литография Принт».

Адрес типографии: 191119, Санкт-Петербург, ул. Днепропетровская, д. 8,
лит. А, офис 14.

e-mail: info@litobook.ru

12+

© Институт восточных рукописей РАН
(Азиатский Музей), 2026

© Коллектив авторов, 2026

В НОМЕРЕ:

К 60-летнему юбилею венгерского монголоведа Агнеш Бирталан	5
--	---

ФИЛОЛОГИЯ

И. А. Алимов. «Дун цзин мэн хуа лу»: Ночной рынок	8
С. Мөнхсайхан. Дундад үеийн монгол хэлний гийгүүлэгч авианы зарим онцлог	14
В. З. Церенов. Горы Богдо в Прикаспийской низменности (варианты одной легенды)	21

ИСТОРИОГРАФИЯ

Э. Гансүх. “Хошуу Наадам” Зургийн Хурдан Морины Шинжийг Судрын Шинжтэй Харьцуулсан Судалгаа	26
--	----

СМЕЖНЫЕ ДИСЦИПЛИНЫ

А. М. Мокеев, К. Белек. Н. Абдимиталип уулу. Истоки философии сострадания Асана Кайгы....	37
М. В. Фиионин. Рукописный перевод М. М. Елизаровой «Завещания Авраама»: текстологическая база и переводческая стратегия	47

НАУЧНАЯ ЖИЗНЬ

М. А. Козинцев, И. В. Кульганек. VI Международная научная конференция «Тюрко-монгольский мир в прошлом и настоящем» (Санкт-Петербург, 16 марта 2026 г.)	64
--	----

ПЕРЕВОДЫ

Р. В. Ивлева. Сэнгийн Эрдэнэ. Дзанабадзар (перевод с монгольского, примечания)	71
--	----

RUSSIAN ACADEMY OF SCIENCES
Institute of Oriental Manuscripts
(Asiatic Museum)



191181, Russian Federation
Saint Petersburg,
Dvortsovaya Emb., 18
Phone: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

MONGOLICA

Saint Petersburg journal for Mongolian studies

Vol. XXIX • 2026 • No. 3

The journal is published four times a year.

Published since 1986

Founder: Federal State Institution of Science
Institute of Oriental Manuscripts of the Russian Academy
of Sciences

Editorial board:

I. V. Kulganek — *editor-in-chief, Dr. Sci. (Philology), Russian Federation*

D. A. Nosov — *secretary, Cand. Sci. (Philology), Russian Federation*

M. A. Kozintcev — *assistant secretary, Cand. Sci. (History), Russian Federation*

G. Bilguudei. *Dr. Sci. (Philology), Mongolia*

A. Birtalan. *Ph. D., Hungary*

S. Chuluun. *Academician of the Mongolian Academy of Sciences, Mongolia*

L. S. Dampilova. *Dr. Sci. (Philology), Russian Federation*

J. Legrand. *Dr. Sci., Professor, France*

V. Kapishovska. *Ph. D., Czech Republic*

E. E. Khabunova. *Dr. Sci. (Philology), Russian Federation*

N. Khishigt. *Ph. D. (History), Mongolia*

E. Munkhtsetseg. *Cand. Sci. (Philology), Mongolia*

S. L. Neveleva. *Dr. Sci. (Philology), Russian Federation*

K. V. Orlova. *Dr. Sci. (History), Russian Federation*

M. P. Petrova. *Ph. D. (Philology), Russian Federation*

R. Pop. *Ph. D., Romania*

Ts. Sarantsatsral. *Dr. Sci. (Philology) Mongolia*

T. D. Skrynnikova. *Dr. Sci. (History), Russian Federation*

R. M. Valeev. *Dr. Sci. (History), Russian Federation*

N. S. Yakhontova. *Cand. Sci. (Philology), Russian Federation*

I. V. Zaytsev. *Dr. Sci. (History), Professor of the Russian Academy of Sciences, Russian Federation*

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/phak-vbt6-avex

© Institute of Oriental Manuscripts
(Asiatic Museum), Russian Academy of
Sciences, 2026

© Group of authors, 2026

IN THIS ISSUE:

On the 60th Anniversary of Ágnes Birtalan	5
---	---

PHILOLOGY

Igor A. Alimov. “Dong Jing Meng Hua Lu”: The Night Market.....	8
---	---

Serjee Munkhsaikhan. Phonetic Features of Middle Mongolian Consonants: Evidence from Chinese-Transcribed Records	14
--	----

Vasiliy Z. Tserenov. Bogdo Mountains in the Caspian Lowland (Variants of a Legend)	21
---	----

HISTORIOGRAPHY

Gansukh Enkhtaivan. “The Hoshuu Festival”. A Study Comparing the Characteristics of Racehorses in the Painting.....	26
---	----

RELATED DISCIPLINES

Anvarbek M. Mokeev, Kayrat Belek, Nursultan Abdimalip uulu. The Origins of Asan Kaighy’s Philosophy of Compassion.....	37
--	----

Maxim V. Fionin. Margarita M. Elizarova’s Manuscript Translation of “The Testament of Abraham”: Textual Basis and Translation Strategy.....	47
---	----

ACADEMIC LIFE

Mark A. Kozintcev, Irina V. Kulganek. The Sixth International Academic Conference “The Turko-Mongol World: Past and Present” (St. Petersburg, March 16, 2026).....	64
--	----

TRANSLATIONS

Regina V. Ivleva. <i>Sengiin Erdene</i> . Dsanabadsar (preface, translation from Mongolian, notes)	71
---	----

Э. ГАНСҮХ

Шинжлэх ухааны технологийн их сургууль

“ХОШУУ НААДАМ” ЗУРГИЙН ХУРДАН МОРИНЫ ШИНЖИЙГ СУДРЫН ШИНЖТЭЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

XX зуунд бүтээгдсэн “Хошуу наадам” хэмээх монгол зураг нь тухайн үеийн овооны наадам, шашин шүтлэг, хурдан морины соёлыг уран сайхны өндөр түвшинд тусгасан бүтээл юм. Зурагт олон хурдан морины хэв шинж, төрхийг ялган, чадварлаг зурсан нь ихээхэн анхаарал татаж байна. Судалгаанд Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн Музейд хадгалагдаж буй “Хошуу наадам” зургийг үндсэн материал болгож ашиглав. Эл зурагт дүрслэгдсэн хурдан морины гадаад шинж, галбирын онцлогийг “Хурдан морины судар”-т тэмдэглэгдсэн шинжүүдтэй харьцуулан анализ хийж авч үзсэн судалгааны үр дүн юм.

Төлхөөр өг: Хурдан морь, Хурдан морины шинж төрх, С. Лувсаншарав, Хошуу наадам уламжлалт зураг.

Зохиогчийн мэдээлэл: Энхтайваны ГАНСҮХ, Ph. D., Шинжлэх ухааны технологийн их сургуулийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл, дизайны сургууль, Дизайны тэнхимийн ахлах багш (Монгол Улс, Улаанбаатар) (gansukh@must.edu.mn).

© Гансүх Э., 2026

XX зуунд бүтээгдсэн¹ “Хошуу наадам” хэмээх монгол зураг нь тухайн үеийн овооны наадам, шашин шүтлэг, хурдан морины соёлыг уран сайхны өндөр түвшинд тусгасан бүтээл юм. Зурагт олон хурдан морины хэв шинж, төрхийг ялган, чадварлаг зурсан нь ихээхэн анхаарал татаж байна. Судалгаанд Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн Музейд хадгалагдаж буй зураач Б. Баттөмөрийн хуулбарлан зурсан (Зураг 1)-ийг үндсэн материал болгож ашиглав. Уг бүтээлийн эх хувь Монголын хувийн цуглуулагчид хадгалагдаж байдаг тухай аман мэдээ бий. Зургийн бүтээгч нь Сүхбаатар аймаг, Сүхбаатар сумын Эрдэнэмандал хийдийн Худуу Шарав хэмээн алдаршсан Гавж С. Лувсаншарав (1907–1996) бөгөөд 1950-иад оны үед цаасан дээр шороон будгаар бүтээсэн

хэмээн зураач М. Эрдэнэбаяр тэмдэглэсэн байдаг. Эл зурагт дүрслэгдсэн хурдан морины гадаад шинж, галбирын онцлогийг монгол бичгээр бичигдсэн нэгэн “Хурдан морины судар” (Зураг 2.)-т тэмдэглэгдсэн гадаад шинжүүдтэй харьцуулан анализ хийсэн судалгаа юм.

Монгол бичгээр бичигдсэн энэхүү судар³ нь хурдан морины гадаад шинжийг дүрслэн бичсэн 17 язгуур шинж байна. Мөн төв халх уяа, сойлог, эрдэнэт хүлгийг засахуй, хурдны морийг шинжихуй, махбодоор шинжихуй, ер шүд шинжлэхуй, сайн унага төрүүлэх гүүний шинж гэгч нь, сайн унаганы шинж, хурдан морийг харайлтаар нь шинжиж зэрэг олон сонирхолтой зүйлсийг бичжээ.

¹ Монгол наадам, Г. Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей, №1/2021 он, ХУ 20.

² Г. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд хадгалагддаг. XX зууны эхэн үед зурагдсан “Хошуу наадам” хэмээх энэхүү бүтээлд Богд хаант Монгол улсын үеийн Сэцэн хан аймгийн Ёст засгийн хошууны нутаг байх Хүслийн таван уулын тахилгын наадмыг төсөөлөн нутгийн төрх байдлыг бодитоор дүрсэлжээ.

³ Зая хүрэнээс олдсон босоо оёмол судар нь 27×13 см хэмжээтэй 36 нүүртэй юм. Энэхүү судар нь Шигамуни бурханд мөргөмүй. Манзуширт залбирмуй гэж эхэлдэг. Энэ судар нь төв халх уяа, сойлог, Эрдэнэт хүлгийг засахуй, хурдны морийг шинжихуй, махбодоор шинжихуй, ер шүд шинжлэхуй, сайн унага төрүүлэх гүүний шинж гэгч нь, сайн унаганы шинж, хурдан морийг харайлтаар нь шинжиж зэрэг олон сонирхолтой зүйлсийг бичжээ. (Хувь хүний цуглуулга. Энэхүү судрыг эх бичиг судлаач Б. Алтантуяагийн хөрвүүлэг)



Зур. 1. С. Лувсаншарав. Хошуу наадам. XX зуун, 71.5×109 см, даавуу, гуаш. Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей. Зураач Б. Батгөмөр хуулбар зураг

Энэхүү зурагт Хүслийн таван уулсын⁴ эзэн савдгуудыг оройдоо ганжир бүхий, сүм дуганы хийцтэй хаалганы өмнө хөх, шар цоохор, бор, цагаан орь хөлөглөн явж буй байдлаар дүрсэлсэн байна. Түүнчлэн сэтэртэй таван хошуу мал, зэрлэг амьтад (буга, согоо, гөрөөс, үнэг, туулай, чоно, могой) болон олон төрлийн шувуудыг бийрээр зурааслан дүрсэлжээ. Зураг дүрслэлийн судалгаа олон янзын үзэл баримтлалаар тайлбарлаж болно. Хамгийн гол нь бид бүхний энэхүү судалгаа философи биш бэлгэдэл зүй бус зөвхөн хурдан морины гадаад шинж төрхийн талаар хийсэн судалгаа тул, зурагт дүрслэгдсэн хурдан морины хэв, шинжийг хурдан морины судар”-ын гадаад шинжтэй харьцуулан хурдан мориныг хэлбэр төрхийн нийлэмжээр нь ангилан анализ хийсэн юм.

Судалгааны аргазүйд

Энэхүү “Хошуу наадам” зурагт судалгааны ажил хийх явцад зураг дээрх хурдан морины

гадаад шинжийн талаар сударт хэрхэн дүрслэн бичигдсэнийг харьцуулан судлах, нэгтгэх хэрэгцээ гарсан юм. Тиймийн учир текст, зураг тэдгээрийн хоорондын ижил төстэй байдлын процессыг CLIP⁵ аргачлалаар судалснаар иконограф болон семантик, семиотик арга зүйн уялдаа холоос, нэгдмэл чанар илүү тодорхой болох боломжтой юм.

Судалгааны үр дүн


Судар Шигэмүни⁶ бурханд мөргөмүй. Манзуширт⁷ залбирмуй хэмээн судар эхэлдэг. Бурханы шашин дэлгэрснээс хойш монгол, төвд судар номын эхэнд өлзий бэлгийг ерөөсөн тарнын үг, мөн өргөл мөргөлийн шүлэг бичих заншилтай болжээ. Үүнээс үүдэн энэхүү судар нь XVII зууны үе болон хойш зохиогдсон болох

⁴ Эрдэнэ мандал уул, Эрдэнэ жавхлант уул, Баян Эрхтэй уул, Баян Мөнх уул, Баян Шарга уул

⁵ CLIP (Contrastive Language-Image Pretraining) загвар нь текстээр дүрслэн бичигдсэнийг, зурган дээрх дүрслэл хэрхэн илэрхийлэгдэх боломжийг олгодог аргачлал юм.

⁶ Бурхан багш

⁷ Оюун Ухааныг тэтгэгч бурхан



Зур. 2. Зая хүрээнээс олдсон босоо оёмол судар.
Хувь хүний цуглуулга

талтай. XVII зуунд зохиогдсон монгол түүхэн сурвалжийн дотор онцгой байр суурьтай “Хураангуй алтан товч”, Лувсансанданзаны “Алтан товч”, “Эрдэнийн товч”, “Шар тууж”, “Асрагч нэртийн түүх” хэмээх 5 түүхэн сурвалж байдаг [Чоймаа, 2011. Х. 5]. Лу. “Алтан товч” [Чоймаа, 2011. Х. 8], “Эрдэнийн товч” [Баярсайхан, 2011. Х. 16], “Асрагч нэртийн түүх” [Заяабаатар, 2011. Х. 17] судруудад адил өлзий бэлгийг ерөөсөн тарнын үг өргөл мөргөлийн шүлэг бичин эхэлсэн байдаг. Үүнээс үүдэн ойролцоо утгатай үг хэллэг олон таарч байна.

Энэ судалгааны ажлаар зургийн хурдан морины шинжийн бэлгэдэл утга тайлал, дүрс, аргументын семиотик тэмдгийн холбоо, семантик утгын судалгаа, иконограф дүрслэлүүдийн нэн чухал утгыг тайлбарлахад CLIP аргачлал нь утгыг нэгдсэн байдлаар боловсруулахад зориулсан шинэлэг загварчлал гэж үзэж байна. “Хошуу наадам” зурагт дүрслэгдсэн хурдан морины дүрслэлд анализ хийхдээ эхлээд ерөнхий хэв шинжээр нь ангилж, сегментчлэн анализ хийлээ. Харин хурдан морины судраас хурдан морины шинжийн дүрслэлийг “Өлгөрдүү”, “Тэгшдүү”, “Бөхгөрдүү” гэсэн гурван үндсэн хэлбэрт хувьсан есөн төрх үүсгэн сегментчлэхэд илүү хялбар болсон. Үүнд:

Өлгөрдүү

Өлгөрдүү өлгөр хэвт: 1. Охин чамбай гэгчийн шинж, 2. Яргай хүлгийн шинж, 3. Уран хаж гэгч морь, 4. Зүр хүлгийн шинж,

Өлгөрдүү тэгш хэвт: 1. Модон ууц гэгч морь, 2. Хүүхэн цэмцэг хэмээгчийн шинж

Өлгөрдүү бөхгөр хэвт: 1. Ажнай хүлгийн шинж

Тэгшдүү

Тэгшдүү өлгөр хэвт: 1. Үнэгэн зоо гэгч морины шинж

Тэгшдүү тэгш хэвт: 1. Хув таяг гэгч морины шинж

Тэгшдүү бөхгөр хэвт: 1. Хатан хараа морины шинж, 2. Өнчин хэт хэмээгчийн шинж


Бөхгөрдүү

Бөхгөрдүү өлгөр хэвт: 1. Хүлгийн шинж, 2. Эрхэм сайн морины шинж нь, 3. Луугийн шинжтэй морь гэгч

Бөхгөрдүү тэгш хэвт: 1. Бүдүүн хүлэг хэмээгчийн шинж

Бөхгөрдүү бөхгөр хэвт: 1. Хайлаасан багана гэгчийн шинж

XX зууны эхэн үед зурагдсан С. Лувсаншаравын “Хошуу наадам” зураг олон хүлгийн хэв шинжийг зурсан байгаа нь анхаарал татдаг. “Хошуу наадам” хэмээх энэхүү бүтээлд Богд хаант Монгол улсын үеийн Сэцэн хан аймгийн Ёст засгийн хошууны нутаг байх Хүслийн таван уулын тахилгын наадмыг төсөөлөн нутгийн төрх байдлыг бодитоор дүрсэлжээ.



Зур. 3. Есөн хурдан морины шинжийн ангилал төрөлжүүлэлд

“Хошуу наадам” (Зураг 3.) дүрслэгдсэн зургийн 1-р хэсэгт дүрслэгдсэн хөх хүлэг⁸ нь “Өлгөрдүү өлгөр хэвт”-тэй галбир нь толгой дээгүүр байрлалтай, тэнгэрийн хаяа харах мэт, хөлөө жийн зогсох, нимгэн арьстай, дэл сүүл шингэн, хөнгөн явдалтайгаар дүрсэлсэн байна. “Тэнгэрийн орны хүлэг”-ийг ер нь бурхдын хүлэг болгон дүрслэх нь элбэг. Зая хүрээнээс олдсон босоо оёмол энэхүү “Хурдан морины судар”-т дурдсанаар “*ökin čimbai gegči-yin singji inü del inü qoyar teyisi, mangnai бүлтегер, segül inü öčүken, del segül inü singgen, ama jögelen, ködelejü*

⁸ Хурдан морийг хүлэг гэдэг [Намнандорж, 1989. Х. 4]. Алдар цуу бүхий гэсэн утгатай, агт, морь, баатар гэсэн үгийн тодотголоор тогтвортой хэрэглэгдэж байгаад улмаар нэршиж орчин цагийн монгол хэлэнд сайн морь, ажнайг нэрлэх болсон [Чоймаа, 2017. Х. 139].

yabuqu-du urdu qojida yabuna. Utubal öngge-ben morin deger-e tolurai-ban talbiqu, keseg keseg güyün güyүkү, kejiyede qajaxar daruqu- үgei, qonsiyar qotuxar bui”. Охин чамбай гэгчийн шинжид дэл нь хоёр тийш, магнай бүлтгэр, сүүл нь өчүүхэн, дэл сүүл нь шингэн, ам зөөлөн, хөдөлж явахад урт хожид явна. Утвал өнгөө морин дээр толгойгоо тавих, хэсэг хэсэг гүйн гүйх, хэзээд хазаар дарахгүй, хоншоор хотгор буй хэмээн бичсэн байна. Мөн “*Uran qaji gegči mori anu čikin-ü üjүgүr qolbun aldaju yabuqu, narin urtu toluraitai, дörben туxurai anu kölüregүtү, segül inü singgen, sinax-a anu öčүken bolai*” Уран хаж гэгч морины шинжийг чихний үзүүр холбон алдаж явах, нарийн урт толгойтой, дөрвөн туурай нь хөлөргүүт, сүүл нь шингэн, шанаа нь өчүүхэн болой гэсэн бол. Яргай хүлгийн шинжийн та-

лаар “*irrai küliig-ün singji inü miq-a-ügei bičiqan tolurrai-tai, narin serteng čiki-tei, küjügi inü urtu, qajuru qabir-a matarasu-tai, segül inü tegsi bui*” шинжид махгүй бяцхан толгойтой, нарийн сэртэн чихтэй, хүзүү нь урт, хажуу хавирга матаастай, сүүл нь тэгш буй хэмээсэн. Зүр хүлгийн шинжийг “*Jür küliig-ün singji inü unaqu-bar barixsan-u qoyin-a xurban qonux-tu ülii kebtékü, bičiqan tolurrai-tai, sibaxun qosixu-tai, göküi del inü singgen tula ene inü sayin küliig bolai*” хэмээн бичсэн байна.

Сударт буй “Охин чамбай гэгчийн шинж”, “Яргай хүлгийн шинж”, “Уран хаж гэгч морь”, “Зүр хүлгийн шинж” 4 гадаад шинжийг бичсэн байна. Харин зургийн 1-р хэсэгт дүрслэгдсэн хөх хүлэгт судрын энэ 4 шинж бүгд байна.

“Хошуу наадам” зургийн 2-р хэсгийн төв хэсэгт чихээ хайчлан зогсох улаан хүрэн хүлгийг дүрсэлжээ. Энэ хэсэгт дурдагдаж буй шинжүүд нь өмнөх шинжүүдийг бодвол арай л том биетэй морьд байдаг. Энэ сударт буй өлгөрдүү тэгш хэвт модон ууц гэгч морины шинжид “*modun aruča gegči mori anu nidü ulaxan, čiki deldeger, borbi ni botura-a-u borbi-tai, unubasu sayibar bui. sayiqan jan-tai bui*” хэмээжээ. Модон ууц гэгч морины нь нүд улаан, чих дэлдгэр, борви нь ботгоны борвитой унаваас сайвар буй, сайхан зантай байдаг гэжээ. Мөн хүүхэн цэмцэг хэмээгчийн шинж нь толгой нь урт хатангир хэмээн эхэлдэг. “*keüken čemčeg kemegčiyin singji inü tolurrai anu urtu qatanggir. terigün degedü urruqu yasu bui quča qabar-tai. čiki inü uran em-e-yin qayiči metü, sidü inü yeke, uruxul anu jujaḡan, qayar qačar del, omuruxu kiged бүкү biy-e-dü yeren ergigülge bui. Eregün-ü angxalaxur axujim. kelen-ü kebtesi maltaxdarsan metü, küjügi inü urtu, köke miq-a anu yeke, omuruxu anu axujim, borbi sidurru, belberkei inü xurban quruxu, silbi inü töge, tururai yeke, qabir-a anu urtu narin, tasiy-a sübegen-ü jabsar xurban quruxu ülii bartaqu oyir bolbasu masi sayin. segül-ün onur-a anu temegen-ü šax-a bartaqu-bar axujim. duqu, seger-e olan yasu neyilekü tegsi, xaxčaxar uyabasu ülii tortaqu, morin lux-a qamtu uyabasu emegel deger-e tolurrai-ban talbiqu, kötülejü yabubal urida qojida ülii yabuqu, sayibar yabudal-tai sayiqan axali-tai. sidün-ü degedü qabsarax bar-a, ilegü jabsar anu kei olan bolbasu sayin. Degedü sidün*

inü ulaxan jubax-tai, sig miq-a qabtaxai, bülkü inü büdügün jögelen bolbasu tere inü sayin” Хүүхэн цэмцэг хэмээгчийн шинж нь толгой нь урт хатангир. Тэргүүн дээд ургах яс хэмээж толгойн шинжийг илүү дурдсан байна. Хуц хамартай, чих нь уран эмийн хайч мэт, шүд их, уруул зузаан, эрүүний ангалзуур уужим, хэлний хэвтэш малтагдсан мэт. Шүдний дээд хавсраг бага, илүү завсар нь хий олон болбоос сайн. Дээд шүд нь улаан зувагтай, шиг мах хавтгай, бүлх нь бүдүүн зөөлөн болбоос тэр нь сайн. Хоёр хацар дэл, омруу хийгээд бүх биед ерэн эргүүлэг буй хэмээжээ. Их биеийн талаар хөх мах их, омруу уужим, хүзүү урт, хавирга урт нарийн, ташаа сүвээний завсар гурван хуруу үл багтах ойр болбоос маш сайн, дух, сээр олон яс нийлэх тэгш, гагцаар уяваас үл тогтох, сүүлийн оноо нь тэмээний шагай багтахаар уужим бол эрхэм сайн гэдэг. Харин дөрвөн мөчний талаар борви шударга, бэрэвхий гурван хуруу, шилбэ төө, туурай их гэсэн бол морин лугаа хамт уяваас эмээл дээр толгойгоо талбих, хөтөлж явбал урьд хожид үл явах, сайвар явдалтай сайхан аальтай гэж дүрслэн бичсэн байна. Зурагт дүрслэгдсэн хурдан морины төрхийг ажвал толгой дээгүүр, хуулзуур шударга, хуц мэт бөгөөд ам хамар их, эрүүний мах яс нь ялгавартай, хэлний хэвтэш агуу, нүд овгор, доод бие буга байдалтай, гишүүн урт, борви тахим сайтай, өвчүүний эн их, хүзүү урт, хавирга их буган шинжит хүлгийг бодогдом зурагдсан байгаа нь судрын шинжтэй дүйж байна.

“Хошуу наадам” зургийн 3-р хэсэгт сэтэртэй хээр морь дүрслэгдсэн байна. Сэтэрт хээр морь нь их амтай, чих богино, мэлхийн магнай мэт тэнүүн магнайтай, нүд том бүлтгэр, эрүү их хэлний хэвтэш агуу, их бие мэлхий мэт гэдсээ татан үсэрч буй мэлхий шиг, хойд хөлөөр урд хөлийг дөрөөлсөн мэт. Энэ дүрслсэн морийг судалгааны ажлын Өлгөрдүү бөхгөр хэвтэй мэлхий язгуурт хүлгийн шинжтэй адил төстэй байна. Сударт “*qamar бүрийен-ü amsar metü, mörү anu jaxan-u mörү metü, qoyar čiki anu tas-un södü metü, qoyar nidü ni inar-un qarča metü, sübege ni bayirulursan obur-a metü. tasiy-a ni qarčax-a öber metü. qabir-a anu matarasu-tai, segül inü xurruul-un metü. Degedü sidü anu kilrasun čaxan, dorudu sidü anu delegü*

čaḡan, kijaxalang, sidüleng, dar-a rurba-yin sidü anu ögedü čulu bolbasu altan temdeg bolai. Nidü anu menekei-yin nidü metü bülteger morai metü bolai. Nidü anu ularan, toluraj anu miq-a ügei gedeger, küjügü anu miq-a ügei bolbasu qurдан-u belge bolai. buru-yin takim metü sayin, qular-un ebčigüü metü anu sayin, küjügü anu urtu bol amisqul-du sayin. Menekei-yin nidü, tas-un södü metü anu sayin. toluraj-yin sayin anu, arslan-u qačar metü, eregün-ü jabsar anu aruu, činu-a-yin ama metü anu sayin. soyux-a anu ider arslan-u-ki metü anu sayin, qarčar-a anu örgen, qabirx-a anu matarasutai anu sayin. jirasun-u jo-a, buru-yin takim, jeger-e-yin qas metü bol sayin, segül-ün yasu qataru, kilrasun üsü ni jögelen ni sayin. Tüngke deger-e yasu anu xadas, tasiy-a, silbi ni buru-yin silbi metü ni sayin. köl-ün rurban singji ni ene bolai. urdu qoyar köl ni sidurxu anu sayin. čegče čimeg čimegsen metü ni sayin. böge ni eregsen metü ni sayin, morai metü jo-a, qabirx-a anu matarasu-tai, küjügü ni narin urtu, jeger-e metü jo-a-tai, čingr-a miq-a-tai bol sayin. niruxu, küjügü silurun urtu böged dörben köl ni boruni bolbasu jirasu adali bolai. arujim yeke ama-tai, delegü bey-e-tei, čiki ni boruni bol erkim sayin” Энэ шинжийг толгой, их бие, дөрвөн мөч гэж хуваан ангилахад. Толгойд хамар нь бүрээний амсар мэт, хоёр чих нь тасын зод мэт, дээд шүд нь хялгасан цагаан, доод шүд нь дэлүү цагаан, хязаалан, шүдлэн, даага гурвын шүд нь өөд цул болбоос алтан тэмдэг болой. Нүд нь мэлхийн нүд мэт бүлтгэр, улаан, хоёр нүд нь янагийн харц мэт, толгой нь махгүй гэдгэр, хүзүү махгүй болбоос хурдны бэлгэ энэ болой гэж. Толгойн сайн нь, арслангийн хацар мэт, эрүүний завсар нь агуу, чонын ам мэт нь сайн. Соёо нь идэр арслангийнх мэт нь сайн. Их биеийн шинжид мөр зааны мөр мэт, харцага өргөн, хавирга матаастай нь сайн, могой болон загасны зоо, бугын тахим, зээрийн хас мэт бол сайн. Бөгс нь эргэсэн мэт нь сайн, сүүлний яс хатуу, хялгасан үс нь зөөлөн нь сайн, сүвээ буулгасан овоо мэт, ташаа харцага өвөр мэт, хавирга нь матаастай, сүүл гургуулын мэт, бугын тахим, хулгын өвчүү мэт нь сайн, хүзүү нь урт бол амьсгалд сайн. Дөрвөн мөчний шинж нь урьд хоёр хөл нь шударга нь сайн, түнхэл дээрх яс нь гадас, ташаа, шилбэ нь бугын шилбэ мэт нь сайн, хөлийн гурван шинж нь энэ болой.

Цэгц чимэг чимсэн мэт нь сайн. Нуруу, хүзүү шулуун урт бөгөөд дөрвөн хөл нь богино болбоос загас адил болой. Уужим их амтай, дэлүү биетэй, чих нь богино бол эрхэм сайн хэмээн бичсэн байна.

Зургийн доод хэсэгт буй хурдан морины уяан дээр зогсох шар хээр хүлгийг 4-р хэсэгт дүрсэлснээр тайлахад арслан цасан дээгүүр харайх наадах мэт агуу хүчирхэг цээжтэй, арслангийн зогдор, омруу хүзүүтэй. Ам хамар их, хоншоор янтгар, дээр бие арслангийн хэвтэй, шар хээр зүстэй морийг зурагт харж болно. Сударт тэгшдүү өлгөр хэвтэй шинжид тохирох нь үнэгэн зоо гэгч морины шинж юм. “*ünegen jo-a gegči morin-u singji inü toluraj bičiqan, sibaḡun qosixutai, küjügü inü urtu, egürseki daxu anu yeke, bey-e narin, qabirx-a anu matarasu-tai, ünegen čiki-tei, nidü inü bülteger, olan mori lux-a qamtu ülü yabuqu, xaxčaxar yabuqu, ulam qola güyüki, qajaxar amatai, dörben köl inü čučasi – ügei, ürgülji yabuqu-du sogsiju yabuqu bičiqan gisgidel-tei, küjügün degegür naqis, sinar-a anu öčüken, ürgülji yabuqu-du-ban toluraj-bar-ıyan torlaju yabuqu, bökeyijü yabuqu, altan qaxalx-a kemeki sidü bolai. sidün-ü üjügür inü dörbeljin narin sudal-tai, dumda qoyar sidü inü boruni bolai*” энэхүү морины шинж нь толгой бяцхан, шувуун хошуутай, хүзүү урт, үүрсэх дуу нь их, бие нарийн, хавирга матаастай, үнэгэн чихтэй, нүд бүлтгэр, олон морь лугаа хамт үл явах, ганцаар явах, улам хол гүйх, хазаар амтай, дөрвөн хөл цуцашгүй, үргэлж явахад шогшиж явах бяцхан гишгэлдэлтэй, хүзүүн дээгүүр нахис, шанаа өчүүхэн, үргэлж явахдаа толгойгоороо тоглож явах, бөхийж явах, алтан хагалга хэмээх шүд болой. Шүдний үзүүр нь дөрвөлжин нарийн судалтай, дунд хоёр шүд нь богино болой хэмээн дүрслэн бичсэн байна.

“Хошуу наадам” зургийн 5-р хэсэгт хөх буурал хурдан морь дүрслэхдээ толгой харц ихэмсэг, хүзүү дээгүүр тавилтай урт хүзүүтэй гэдгэр дүү зурагджээ. Энэхүү судалгааны тэгшдүү өлгөр хэвтэй гөрөөсөн язгуурт хүлгийн шинжтэй тун төстэй. “*qubi tayaḡ gegči morin-u singji anu kegegere bey-e-tei, qangqar tasiya-a-tai, degedü bey-e inü aruu, doradu bey-e qomsu, omuruu-u üsü serbeḡer, küjügün ni gürdeger, sirbüsün ni büdügün bui*” хув таяг гэгч морины шинжийг сударт зэгзгэр биетэй, хонхор ташаатай, дээд бие нь

агуу, доод бие хомс омрууны үс сэрвэгэр, хүзүү нь гүдгэр, шөрмөс бүдүүн хэмээсэн байна. Зурагт дүрслэгдсэн хөх буурал хурдан морь нь судартай харьцуулахад хавирга нь матаастай, өвчүү цээж төвгөр онгоцны хитэг мэт, дөрвөн мөч урт, өндөр, тэгш чанга бусгамтгай үргэмтгий, хөнгөн ясны ер нь гоёмсог төрхтэй, согоон чихтэй дүрсэлсэн байна.

Зургийн 6-р хэсэгт буй хээр алаг хурдан морь нь хүзүү галууных мэт урт нарийн бөөрөнхий чанга, тормон нүдтэй, чих урт тасын өд мэт, доод уруул дээдхээсээ илүү гарсан унжгар, хамар дээгүүр шувуун судастай, туулай дуу толгойтой. Хавирга шинийн гуравны сар мэт, бүргэдийн мөртэй, ботгон борвитой, мундаа сайтай. Гуя гунжин ингэнийх мэт, дөрвөн тулгуур уртлаг, үе томтой дүрсэлжээ. Сударт тэгшдүү бөхгөр хэвтэй дүйж буй өчин хэт хэмээгчийн шинжид “*önücin kete kemegçi –yin singji inü tolurái qatanggir čiki inü nimgen urtu, nidiün-ü qar-a bar-a, sandarqai anu jabsar-tai, aman küjügü yeke eregün-ü anggaljaṣur agujim, kele nimgen, jür-ün-ki sig urtu narin küjügü-tei, büberkei yeke, bulčing anu bülteger, köke miq-a, omuruṣu anu aṣujim, saṣar anu mončor metü tuurai anu ayaṣ-a metü, qondulai degere ergigülge-tei. qabirr-a anu arux metü. önyün sübege tasiy-a qoyar-un qorurundu qururu ülü barṣaqu, tasiy-a anu bürgüd-ün dalabči metü. segül-ün onux-a anu yeke šar-a barṣaqu-bar zai-tai, segül-ün qilrasu anu yongqur utasu metü. gedesü bumba metü, borbi anu mergen er-e-yin erekei metü*” Толгой хатангир, хэл, чих нимгэн урт, нүдний хар бага, цагаан их, хамар их, дээд уруул ихтэй зовхи өндөр, магнай мах тасархай, эрүүний ангалзуур уужим гэсэн бол. Их биеийн шинжид аман хүзүү их, зүрийнх шиг урт нарийн хүзүүтэй, бүдэрхий их, булчин бүлтгэр, хөх мах их, омруу уужим, хавирга араг мэт. Өнчин сүвээ ташаа хоёрын хооронд хуруу үл багтах, ташаа нь бүргэдийн далавч мэт, сүүлийн оноо их шагай багтахар зайтай, сүүлийн хялгас ёнхор утас мэт, гэдэс бумба мэт хэмээсэн. Доод дөрвөн мөчний шинж нь хондлой дээрээ эргүүлэгтэй, борви мэргэн эрийн эрхий мэт, сагаг нь монцог мэт, туурай хөмөрсөн аяга мэт хэмээн дүрслэн бичсэн байна. Хатан хараа морины шинжид “*qatan qarar-a morin-u singji ni ama, qamar yeke,*

del segül singgen, бүкү би-е-дү-бен эргигүлге-теи, narin sebsger čiki-tei, egürsekü-dü-ben qarjiginiqu, nidiü ni qonin nidiü adali bui” ам, хамар их, дэл сүүл шингэн, бүх биедээ эргүүлэгтэй, нарийн сэвсгэр чихтэй, үүрсэхдээ харжигнах, нүд нь хонин нүд адил буй. Энэ хоёр шинжид дүрслэн бичигдсэн шинж нь хээр алаг морины гадаад шинжтэй адил байна.

Зургийн 7-р хэсэгт нь хөгшин хээр морь уяагаа санагалзан зогсох нь судалгааны бөхгөрдүү өлгөр хэвтэй дүйж байгаа юм. Сударын хүлгийн шинжид “*tolurái ni qandarai-yin tolurái metü, dörben silbi ni buru-yin čaču metü, arṣal-un berbekei-tei, tayıran borbi-tai uraljanbey-e, obur-a-tai. kükege buyu čarar mögersü ni tomu, aman küjügü бүдүгүн, küjügü urtu, mungda ni sarlux-un qayınux-un serbege metü, büberkei ni urursi-ban masi tobuxar, mörü dalu-bar-ıyan tasıru urtu bögterge, alus-ača-ban matararasu-tai, yeke qabirr-a ni örger radarısi-ban teligü urtu matararasu-tai, qorurundu-yin jai bar-a, önyün sübegen-ü qabirr-a, tasiyan tolurái qoyar-un qorurunduki jai bar-a, urtu nalaru qondulai-tai, tomu saltaratai, borbi šarantu бүдүгүн, qoyar toyır-ıyar-ıyan radarısi teligü, qoyidu qonru ni bosur-a degedü rurban obur-a tegsi qar-a ruyan-u köke miq-a, bulčing tobuxar yeke, silbi qatanggir qabtarai, бүкү бex-yin arisu sula, aman küjügü бүдүгүн, küjügü urtu nimgen čabi yeke, sur-a-yin arisu olan nurararsan, dörben köl badırarun, radarısi-ban telger mayır-tai, dörben möči-yin sirbüsün güreyijü ile qararṣaqu, sirbüsün qoyar niruxun-u ebüdüg neyilen ayaṣ-a kömüregsen metü, čulu qar-a tuxurai. tolurái deger-e bisi omuruṣu- ača urdu köl-ün jai yeke büberkei-eče mungdar-a kürtel-e jai yeke, sübergedesü guy-a tasiyan-ača narar-a tömbüger bayın-a. eyimü bayidal erkim*” хэмээсэн байна. Шинжийг хураангуйлахад толгой нь хандгайн толгой мэт. Их биеийн шинж нь хүхээ буюу цагаан мөгөөрс том, аман хүзүү бүдүүн, хүзүү урт, мундаа нь хайнагийн сэрвээ мэт, бүдэрхий урагшаа маш товгор, мөр далаараа ташуу урт, бөгтрөг нь алсаасаа матаастай, хавирга нь өргөн гадагшаа тэлүү, урт матаастай, хоорондын зай бага, өнчин сүвээний хавирга, ташаан толгой хоёрын хоорондох зай бага, урт налуу хондлойтой, дээд гурван овоо тэгш хаа гуяны, хөх мах, булчин товгор их, бүх биеийн арьс сул,

аман хүзүү бүдүүн, хүзүү урт нимгэн цавь их, суганы арьс олон нугарсан мэт. Доод дөрвөн мөчний шинж нь дөрвөн шилбэ бугын чац мэт, аргалын бэрэвхийтэй, тайган борвитой, шилбэ хатангир хавтгай, дөрвөн хөл бадируун, гадагшаа тэлгэр маягтай, дөрвөн мөчний шөрмөс гүрийж ил харагдах, шөрмөс хоёр нурууны өвдөг нийлэн аяга хөмөрсөн мэт, цул хар туурай. Том салтаатай, борви шаант бүдүүн, хоёр тойгоороо гадагшаа тэлүү явах, хойд хонго нь босоо, толгой дээр биш омруунаас урьд хөлийн зай их бүдэрхийнээс мундаа хүртэл зай их, сүврэгдэс гуя ташаанаас наана төмбөгөр байна. Ийм байдал эрхэм сайны шинж юм. Мөн эрхэм сайн морины шинжид “*Erkim sayin morin-u singji nidü ni sirigün qarača-tai böged sirbüsün ni serteger, çegeji ni nimgen, qabčiru, mangnai ni jujарan, berbekei ni boruni, qoyidu tururai-yin morulčar urtu, sirbüsün ni kei-tei telegü, örgen, serbege öndür, aman küjügü бүдүгүн, toluxai-yin miq-a qatanggir, olan yasun-u aruljaburi aruu, sübegen-ü qabirx-a matarasu-tai telegü, tasiy-a ni čuqal qas ni dügüreng, saltar-a ni aruu, jo-a niruru ni bögtege-tei, köl ni eres sidurgu, küjügü ni urtu narin segül ni erčim-tei qataxu, böge ni qatanggir edeger singji čöm būridbel tümen mingrad törükü tüdekü-ügei xaxčaxar түрүгүлкү amui*” сударт дүрслэн бичигдсэн энэхүү шинжийг үгчлэн хөрүүлэхэд “Эрхэм сайн морины шинж нь нүд нь ширүүн харцтай бөгөөд шөрмөс нь сэртгэр, цээж нь нимгэн, хавчуу, магнай нь зузаан, бэрэвхий нь богино, хойд туурайн моголцог урт, шөрмөс нь хийтэй тэлүү, өргөн. Сэрвээ өндөр, аман хүзүү бүдүүн, толгойн мах хатангир, олон ясны уулзвар агуу, сүвээний хавирга матаастай тэлүү, ташаа нь цухал хас нь дүүрэн, салтаа нь агуу, зоо нуруу нь бөгрөгтэй, хөл нь эрс шударга, хүзүү нь урт нарийн сүүл нь эрчимтэй хатуу, бөгс нь хатангир эдгээр шинж цөм бүрдвэл түмэн мянгад төрөх түдэхгүй ганцаар түрүүлэх амуй” дүрслэгдэн бичсэн байна. Сударт луугийн шинжтэй морь гэгч нь “*luu-yin singji-tei mori gegči ni mangnai oburar, nidü ni бүlteger, niruru tegsi, qarčax-a örgen, qabirx-a matarasu-tai, küjügü ni urtu, čingx-a boruxan-du saiyin güyүкү bolai*” луу шинжтэй морь нь магнай овгор, нүд бүлтгэр, нуруу тэгш, харцага өргөн, хавирга матаастай, хүзүү нь урт, чанга

бороонд сайн гүйх болой хэмээжээ. Луу язгуурт хүлгийн шинжийн төрхтэй адил байгааг үзвэл толгой нь дээгүүр биш мөн доогуур ч биш яг л завсраар нь буюу мундаа, хондлойн өндөртэй тэгш хэмд толгой байрлан, 4 хөл тэгш жигд зогсож байна. Хээр хурдан морь нь магнай овгор, нүд бүлтгэр, гавал их, чих урт тасын өд мэт. Хамрын хуулзуур урт, уруул ам сайтайн дээр хүзүү уртын нь чийг бороонд сайн гүйнэ. Сэрвээ өндөр, нуруу тэгш, харцага өргөн, хавирга матаастай, их бие уртлаг бөөрөнхийдүү хэвтэй ч гуя хас сул, тэгш холд сайн гэх мэт. Хондлойн буулт тэгш, дөрвөн хөл жигт зогссон байна. Энэ шинжийн хурдан морь олон сударт их дурдагддаг шинж билээ.

Зургийн 8-р хэсэгт бөхгөрдүү тэгш хэвтэй хурдан морь нь толгойгоороо газар шагайн, 4 хөлөө хумин зогсож байгаа нь судрын бүдүүн хүлэг хэмээгчийн шинжтэй дүйж байна. “*bүдүгүн күлүг кемегчи-yin singji ni dörbeljin toluxai-tai, noqai qamar-tai, orutan-u nidүtei, urtu küjügү-tei. Dörbeljin bey-e-tei, qotuxar niruxu-tai. Čegeji böge ni tegsi, xuy-a бүдүгүн, ama ni aruu, çegejin-degen yesün ergigülge-tei, bögsen-dү-ben naiman ergigülge-tei. Ene mori čučaqu-ügei, untaqu-ügei, keger-e mori morim-ača ilegүү sayin. olan aduxun-du oruju yabuqu-du urtan qaraq, ereken-dү tarrun čidqulang-du anu üjebel deger-e xurban obur-a tegsi door-a, kebeli bumba metü. nidü čiki ni deldege daruxdaqu-ügei. Degedü ururul-ača doxudu uruxul yeke, urdu tururai-ača qoyidu tururai yeke*” шинжид дөрвөлжин толгойтой, нохой хамартай, оготнын нүдтэй, урт хүзүүтэй. Дөрвөлжин биетэй, хотгор нуруутай. Цээж, бөгс тэгш, гуя бүдүүн, ам агуу, цээжиндээ есөн эргүүлэгтэй, бөгсөндөө найман эргүүлэгтэй. Энэ морь цуцахгүй, унтахгүй, хээр, морь мориноос илүү сайн. Олон адуунд орж явахад угтан харах, эрэхэд тарган цатгаланд нь үзвэл дээр гурван овоо тэгш доор, хэвэл бумба мэт. Нүд чих нь дэлдээ дарагдахгүй. Дээд уруулаас доод уруул их, урд туурайнаас хойд туурай их гэх мэт хэмээсэн байна. Хүрэн зүсмийн морийг судрын шижид дурдсанаар туулай толгойтой нүд их, хоншоор нарийн, чих урт, хэлний хэвтэш агуу, туулай зоотой, хойд хөл уртлаг, хондлой өндөр, бөгсний буулт огцом налуутай, хөгшин ямаа бороонд бээрч зүдэж байх мэт хэ-

лбэртэй, толгойгоо дээш доош хөдөлгөн нүүр нь уртаараа савхан дуу, дөрвөн мөч цомцуу, үзэсгэлэн гоо бус бөхгөрдүү тэгш хэвттэй хурдан морьтой адил дүрслэгджээ.

Зургийн 9-р хэсэгт нойрмоглосон, хүдэр биетэй хэт хол бартаат замд цуцахааргүй янтгар ам хамартай, чих далдгар нуруугаар хотгор, бөгтрөг их, хөл майга, мойногдуу тавил гишгэлтэй бөхгөрдүү бөхгөр хэвтэй морь дүрсэлсэн байна. Сударт хайлаасан багана гэгчийн шинжид *“qayilagasun baxan-a gegči-yin singji ni köl boruni, bey-e büdügün, gedesi yeke, qoyar nidü ni qurča, yeke nomuqan sayin qatarulqu kete köl-dü sayin. ene čax-tu bui gekü öbül, qabur del dügüreng uruldu, güyüki bui usun-u bax-a anu sayin. jun, namur usu yekedegül, ulaxan ögekütei-eče-ben dorursi qalim-ača degesi sidün-dü-ben ali joqirsan-ača medejü uraldu. Ajinai metü külüg-üd delgeretügei. Asida-yin xurban erdeni sakiturai, degedü dörben obux-a tengčegü öndür, yeke keb anu qabčiru, toluray miq-a-ügei, qoyar čiki, tuṣuray anu aṣuu, tasiy-a yeke qalim bolumui. tuṣuray kömüregsen ayaṣ-a metü yeke, silbi qoyar barim, nige qururu, berbekei inü nige barim sirmüsün bitegü yeke sayin”* шинжид хөл богино, бие бүдүүн, гэдэс их, хоёр нүд хурц, их номхон сайн хатуулах хэт хөлд сайн. Энэ цагт буй гэх мэт өвөл, хавар дэл дүүрэн уралд, гүйх буй усны бага нь сайн. Зун, намар ус ихдүүл, улаан өөхтэйгөөс доош халимаас дээш шүдэндээ аль зохисноос мэдэж уралд. Ажнай мэт хүлгүүд дэлгэртүгэй. Ашдын гурван эрдэнэ сахитугай. Дээд дөрвөн овоо тэнцүү өндөр, их хэв нь хавчуу, толгой махгүй, хоёр чих урт, туурай агуу, ташаа их халим болмуй. Туурай хөмөрсөн аяга мэт их, шилбэ хоёр барим, нэг хуруу, бэрэвхий нэг барим шөрмөс битүү их сайн гэдэг энэ нь бас сайн унааны морь байдаг.

“Хошуу наадам” зурагт дүрслэгдсэн хурдан морьд нь хурдан морины сударт өгүүлсэн гадаад шинжүүдтэй нийцэж байна. Энэ нь зураач С.Лувсаншаравын бүтээл нь морфологийн мэдлэгт тулгуурлан, бүтээгдсэн урлаг судлалд чухал эх сурвалж болох үнэ цэнтэй бүтээл юм. Ер нь монгол уран бүтээлчид хурдан морийг зурж дүрслэхдээ өөрийн адуу, эсвэл нутаг орондоо алдартай хурдан хүлгүүдийг дүрслэх нь элбэг бөгөөд “Хошуу наадам” зураг ч мөн адил бо-

дит амьдралаас урган гарсан, ард түмний дунд алдартай хурдан морьдыг зурж дүрсэлсэн нь Монголчуудын хурдан морийг дээдлэх үзэл, эстетикийн өндөр ойлголтойг илтгэнэ.

Судалгааны хэлэлцүүлэг

“Хошуу наадам” зурагт олон морьдын дүрслэл байгаа ч сударт буй гадаад шинжтэй нийцэж байгаа 16 шинжүүд дээр анализ хийсэн. Морьдын хэлбэр төрхөөр нь сегментчлэхэд 9 төрх үүссэн юм. Энэхүү дүр төрхийг (Зураг 3.)-т өлгөрдүү өлгөр хэвт, өлгөрдүү тэгш хэвт, өлгөрдүү бөхгөр хэвт, тэгшдүү өлгөр хэвт, тэгшдүү тэгш хэвт, тэгшдүү бөхгөр хэвт, бөхгөрдүү өлгөр хэвт, бөхгөрдүү тэгш хэвт, бөхгөрдүү бөхгөр хэвт дүр төрхөөр байрлуулан шинжсэн юм.

Энэхүү зурагт цаашид шашин, нүүдэлчдийн философи, бэлгэдэл зүй, материал зэрэг судлах зүйл олон байна. Сударт ч олон дотоод болон нууцын шинжүүд судлан, судалгааны эргэлтэд оруулах нь зөв биз. Жишээ нь: Зургийн 10-р хэсэгт хурдан морины уралдааныг дүрслэгдсэнийг сударт буй харайлтаар нь шинжиж болно хэмээснийг харьцуулсан юм. (Зураг 4.) “Сударт зээр, чоно, туулай, тогоруу давхилын талаар дурдсан байна. Зурагт дүрслэгдсэн хурдан морьдыг “чонын харайлттай адууг ажихад их сунаж, урд хөлийн үзүүр хошуунаас өнгөрч давхиж харагддаг. Шөрмөс сайтай учир тэнийлт сайны нэгэн шинж энэ болой. Туулай шиг харайдаг морь нь бие хойноос урагш, хөл шидэж үсэрч байгаа мэт харагддаг. Ийм морь хоёр чих нь урагш болж, босоо байдалтай харайдаг нь дээд нэг шинж мөн. Өндөр цээжтэй, ганагардуу морь газрын урууд сайн. Тогоруу цээжтэй, овгордуу хондлойтой адуу өгсүүр газар сайн бай-



Зур. 4. Морийг харайлтаар нь шинж

даг. Ясны хурд, шөрмөсний хурд, хүч тамирын, бярын, угшлын, эсгэлийн бүх шинж бүрдсэн хурдан морь маш ховор. Аль л олон шинж буй бол тэр хэмжээндээ л хурдалдаг” хэмээсэн. Тийм ч учраас хурдан морьдын тухай олон сайхан судалгааг хийхээр байна.

Монголын дүрслэх урлагийн хурдан морины дүрслэлтэй нэгэн бүтээлд судартай харьцуулан судалгаа хийлээ. Морьдын толгой хүзүүний байрлал болон ерөнхий биеийн хэлэмжээр нь “Өлгөрдүү”, “Тэгшдүү”, “Бөхгөрдүү” хэмээн гурван хэлбэрт хуваан ангилсан. Энэхүү ерөнхий гурван хэлбэрээр сегментчлэхэд 9 төрх үүссэн юм. Ингэж ашигласнаар хурдан морийг ялгаж анализ, дүн шинжилгээ хийх бүрэн боломжтой болсон юм.

Энэхүү С. Лувсаншаравын “Хошуу наадам” зурагт олон үйл явдал өрнөж байгаа. Тэр бол-

гоныг нэг судалгааны өгүүлэлд багтаах ямар ч боломжгүй тул. Зөвхөн хурдан морины шинжийн талаар л харьцуулсан судалгаанд хийсэн үр дүнг танилцуулж байна. “Хошуу наадам” зургаас харахад уран бүтээлч маань адуу мал сайн мэддэг, удам дамжсан хурдан морины шинжээч байж магад. Ер нь хурдан морь бүтээдэг уран бүтээлч хүн ямарваа уран бүтээл туурвихдаа өөр, өөрийн мэдрэмж, авьяас чадвараас хамаарч утга санаа, дүрээ бүтээдэг. Тэр тусмаа хурдан морьдыг дүрслэхдээ өөрсдийн адууны юм уу эсвэл нутаг орондоо алдартай хурдан морьдоо ихэнхдээ дүрсэлсэн байдаг. Судалгааг хийхдээ зураг, судрын эх сурвалж харьцуулан судалж, нэгтгэн дүгнэж, үр дүнтэйгээр дүрийг гаргах нь цаашдын шинжлэх ухааны судалгаа шинжилгээнд хэрэг болуужин хэмээн бодном.

Ашигласан эх сурвалж

Хурдан морины судар, босоо судар. Гар бичмэл. Зая хүрээ.

Лувсаншарав С., Б. Баттөмөр. Хошуу наадам. Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей.

Ашигласан ном зүй

Баярсайхан, 2011: *Баярсайхан М.* Хаадын үндэсний эрдэнэийн товч. Улаанбаатар, 2011.

Заяабаатар, 2011: *Заяабаатар Д.* Асоагч нэргийн түүх. Улаанбаатар, 2011.

Намнандорж 1989: *Намнандорж О.* Монголын хурдан морины тухай”. Улаанбаатар, 1989.

Чоймаа, 2011: *Чоймаа Ш.* Лувсанданзаны зохиосон Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиосон товчлон хураасан алтан товч хэмээх оршвой. Улаанбаатар, 2011.

“THE HOSHUU FESTIVAL”. A STUDY COMPARING THE CHARACTERISTICS OF RACEHORSES IN THE PAINTING

Enkhtaivan GANSUKH

Mongolian University of Science and Technology

The article analyzes the features of the appearance and build of racehorses as depicted in the painting “Khoshun Festival” by the 20th-century Mongolian artist S. Luvsansharav. The painting, which is a significant work of Mongolian visual art, is now preserved in the Zanabazar Museum of Fine Arts. Its title derives from the word *khoshun*, which denoted a territorial unit in old Mongolia. On the canvas, the artist, masterfully reflecting the cultural and everyday features of his time, conveyed the atmosphere of the Ovoo festival and, in particular, demonstrated various types of racehorses. As part of the study, the features of the horses depicted in the painting are compared with the characteristics provided in the “Racehorses sutra” from the 17th century.

Key words: racehorse, S. Luvsansharav, traditional painting, iconography.

About the author: **Enkhtaivan GANSUKH**, Ph. D., Department of Design, School of Food, Light Industry and Design, Mongolian University of Science and Technology (Ulaanbaatar, Mongolia) (gansukh@must.edu.mn).

ИЗОБРАЖЕНИЕ СКАКОВЫХ ЛОШАДЕЙ НА КАРТИНЕ «ХОШУННЫЙ ПРАЗДНИК»

Энхтайван ГАНСУХ

Монгольский университет науки и технологии

В статье анализируются особенности внешнего вида и телосложения скаковых лошадей, представленные на картине «Хошунный праздник» монгольского художника XX века С. Лувсаншарава. Картина, являющаяся значительным в художественном плане произведением монгольской живописи, ныне хранится в Музее изобразительных искусств Дзанабадзара. Ее название происходит от слова «хошун», означавшего территориальную единицу старой Монголии. На полотне художник, мастерски отразив культурно-бытовые особенности своего времени, передал атмосферу праздника Овоо и, в частности, продемонстрировал различные типы скаковых лошадей. В рамках исследования черты лошадей, изображенных на картине, сравниваются с характеристиками, которые приводятся в «Сутре о скаковых лошадях» XVII в.

Ключевые слова: Скаковая лошадь, С. Лувсаншарав, традиционная живопись, иконография.

Информация об авторе: Гансукх Энхтайван, Ph. D., кафедра дизайна, Школа пищевой, легкой промышленности и дизайна, Монгольский университет науки и технологий (Монголия, Улан-Батор) (gansukh@must.edu.mn).